



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/127

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийг батлагдсан орон тоо, цалингийн зэрэглэлийн хамт 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд харьяалуулсантай холбогдуулан “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн баталсан дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга (цагдаагийн хурандаа П.Батбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (бригадын генерал Ц.Ням-Очир)-д даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2023 оны А/286 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Т.СҮХБОЛД

Цагдаагийн ерөнхий газрын даргын
2024 оны 03 дугаар сарын 15-ны
өдрийн 1/1 дугаар тушаалын
1 дугаар хавсралт



МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ ДҮРЭМ

I. Нийтлэг үндэслэл

1. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба (цаашид алба гэх)-ны чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн зарчим, ажлын дотоод зохион байгуулалт, алба, түүний харьяа нэгжийн дарга, алба хаагчдын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү дүрмийн зорилго оршино.

2. Алба нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Статистикийн тухай, Харилцаа холбооны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, энэхүү дүрмийг тус тус удирдлага болгоно.

3. Албаны үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай зарим журмыг цагдаагийн төв байгууллагаас эрх шилжүүлэн авсны үндсэн дээр албаны дарга батлан мөрдүүлж болно.

4. Алба нь гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих, статистикийн мэдээ, тайлан боловсруулах, дүн шинжилгээ хийх, харилцаа холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчил болон гамшиг, осол, эмнэлгийн яаралтай тусламжийн дугаарын утсанд иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэн дамжуулж, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын ажил хариуцсан нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, дээд шатны байгууллага, албан тушаалтныг мэдээ, мэдээллээр хангах үүрэг бүхий цагдаагийн төв байгууллагын харьяа зохион байгуулалтын бүтцийн нэгж мөн.

5. Алба, түүний харьяа нэгж нь холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

II. Нэр томъёоны тодорхойлолт

6. Энэ дүрэмд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

6.1. “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага” гэж цагдаагийн байгууллага, алба хаагчид хандаж, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, үйлдэгдэж буй болон үйлдэгдсэн талаар иргэн, албан тушаалтнаас харилцаа холбооны хэрэгслээр цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт дамжуулж байгаа мэдээ /өгөгдөл/-г;

6.2. “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, үйлдэгдэж буй болон үйлдэгдсэн талаар иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс амаар, бичгээр болон бусад хэлбэрээр

дамжуулж байгаа мэдээ /өгөгдөл/-г;

6.3. “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол” гэж гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж, эрхээ сэргээлгэхээр иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс цагдаагийн бүх шатны байгууллагад хандаж гаргасан хүсэлтийг;

6.4. “Гомдол, мэдээллийн сан” гэж иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж, сэргээлгэхээр гаргасан хүсэлт болон гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад ирүүлсэн мэдээллийг тусгайлан боловсруулсан программ хангамжаар шивж, цахим хэлбэрээр бүрдүүлсэн мэдээллийн санг;

6.5. “Гэмт хэргийн мэдээллийн сан” гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлд холбогдох мэдээллийг тусгайлан боловсруулсан программ хангамжаар шивж, цахим хэлбэрт оруулсан мэдээллийн санг;

6.6. “Зөрчлийн мэдээллийн сан” гэж зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан тусгайлан боловсруулсан программ хангамжаар зөрчлийн тоо бүртгэлд холбогдох мэдээллийг шивж, цахим хэлбэрт оруулсан мэдээллийн санг;

6.7. “Гэмт хэргийн статистикийн мэдээ” гэж гэмт хэргийн цахим мэдээллийн сангаас тогтсон үзүүлэлт, аргачлалаар боловсруулсан гэмт хэрэг, яллагдагч, хохирогч иргэн, хуулийн этгээд, бүртгэгдсэн хэргийн болон түдгэлзүүлсэн хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлт, прокурорын шаардлага, түүний мөрөөр зохион байгуулсан ажил, хариу өгсөн тухай статистик тоон үзүүлэлтийг;

6.8. “Зөрчлийн статистикийн мэдээ” гэж зөрчлийн цахим мэдээллийн сангаас тогтсон үзүүлэлт, аргачлалаар боловсруулсан зөрчил, түүнийг үйлдэгч, хохирогч иргэн, хуулийн этгээд, зөрчлийн шийдвэрлэлтийн тухай статистик тоон үзүүлэлтийг;

6.9. “Дүн шинжилгээ, судалгааны ажил” гэж цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны явцад цугларсан ил болон нууц мэдээ, мэдээлэл, бусад эх сурвалжаас олж авсан мэдээллийг нэгтгэх, харьцуулах, дүгнэлт хийх, нарийвчлан судлах үйл ажиллагааг;

6.10. “Ил мэдээлэл” гэж хэвлэл, цахим хэвлэл (гадаад, дотоод) мэдээллийн бусад хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ (facebook, twitter гм) болон ЦЕГ-ын албадаас ирүүлсэн нууцын зэрэглэлгүй илтгэх хуудас, тайлан, танилцуулга, мэдээ, мэдээллийг;

6.11. “Кибер аюулгүй байдал” гэж кибер орчинд мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдал хангагдсан байхыг;

6.12. “Шуурхай удирдлагын үйл ажиллагаа” гэж гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дамжуулах, хуваарилах, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх, ул мөрийг хамгаалах, хойшлуулшгүй ажиллагаа явуулах, түүнээс урьдчилан сэргийлэх, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах зэрэг тодорхой ажиллагаанд цагдаагийн байгууллагын хүч хэрэгслийг оновчтой ашиглах, нэгж, алба хаагчийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, удирдлагыг мэдээллээр хангах ажиллагааг;

6.13. “Шуурхай удирдлагын бүрэлдэхүүн” гэж хоногийн хугацаанд шуурхай удирдлагын ажил хариуцсан нэгжид хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдаас бүрдсэн томилгоот бүрэлдэхүүнийг;

6.14. “Хэргийн газрын үзлэгийн баг” гэж хоногийн хугацаанд холбогдох томилгоо, хуваарийн дагуу Шуурхай удирдлагын бүрэлдэхүүнд ажиллаж, хэргийн газрын үзлэг хийх, хойшлуулшгүй ажиллагаа явуулах үүрэг бүхий жижүүрийн ахлах мөрдөгч, хэргийн газрын үзлэгийн мэргэшсэн шинжээч, жижүүрийн цагдаа-жолооч зэрэг албан тушаалтнуудаас бүрдсэн бүрэлдэхүүнийг;

III. Үйл ажиллагааны үндсэн зарчим

7. Алба нь үйл ажиллагаандаа дараах үндсэн зарчмыг баримтална.

7.1. хууль дээдлэх;

7.2. хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

7.3. ил тод, нээлттэй байх;

7.4. нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх;

7.5. үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах;

7.6. кибер аюулгүй байдлыг хангах;

7.7. техник, технологийн ололтыг нэвтрүүлэх;

7.8. статистикийн үйл ажиллагаа нь хараат бус, бие даасан, шинжлэх ухааны үндэслэл бүхий олон улсын стандарт, нэгдмэл арга зүй дээр тулгуурласан бодит мэдээллийг нийтэд хүртээмжтэй байдлаар хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд ил тод байлгах;

7.9. нууцыг чанд хадгалах.

IV. Зохион байгуулалтын бүтэц, удирдлагын үйл ажиллагаа

8. Албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоог Цагдаагийн ерөнхий газар /цаашид ЦЕГ гэх/-ын дарга тогтооно.

9. Албыг ЦЕГ-аас томилсон албаны дарга удирдах ба ЦЕГ-ын Тэргүүн дэд даргад харьяалагдана.

10. Алба чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай захиргааны удирдлагын, статистик мэдээллийн, дүн шинжилгээ, судалгааны, холбооны, мэдээллийн технологийн, кибер аюулгүй байдлын, мэдээлэл, шуурхай удирдлагын чиглэлээр мэргэшсэн үйл ажиллагаа явуулах бөгөөд бусад зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй байж болно.

11. Бүтцийн нэгж байгуулах, татан буулгах, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх асуудлыг ЦЕГ-ын Тэргүүн дэд даргатай зөвшилцсөн албаны даргын саналыг үндэслэн ЦЕГ-ын дарга шийдвэрлэнэ.

12. Албаны даргын дэргэд зөвлөх эрх бүхий даргын дэргэдэх зөвлөл ажиллах ба зөвлөлийн бүрэлдэхүүнийг ЦЕГ-ын даргын тушаалаар томилж, чөлөөлнө.

13. Алба нь цагдаагийн төв байгууллагын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын хэлтэс, тасаг, ажил хариуцсан алба хаагч, ажилтны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

14. Алба нь үйл ажиллагаагаа улирал тутам ЦЕГ-ын Тэргүүн дэд даргад, хагас бүтэн жилээр ЦЕГ-ын даргад тус тус ажлаа тайлагнана.

V. Албаны үндсэн чиг үүрэг

15. Алба дараах үндсэн чиг үүргийг цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлнэ.

15.1. Гэмт хэрэг, зөрчил болон гамшиг, осол, эмнэлгийн яаралтай тусламжийн талаарх дуудлага, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дамжуулах, хуваарилах, хойшлуулшгүй ажиллагаа зохион байгуулах, зарлан мэдээлэх, дээд шатны байгууллага, албан тушаалтныг мэдээ, мэдээллээр шуурхай хангах;

15.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчил болон эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн сангийн баяжилт, хөдөлгөөн, түүний бодит байдалд хяналт тавих, статистикийн мэдээ, тайлан боловсруулах, хэрэглэгчдийг шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах, лавлагаа олгох;

15.3. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, статистик тоон мэдээнд дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, дээд шатны байгууллага, албан тушаалтныг бодит мэдээ, мэдээллээр хангах, удирдлагаас бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

15.4. Судалгаа, дүн шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын болон бусад ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, тэргүүн туршлагыг судлах, орчин үеийн дэвшилтэт техник технологи, арга зүйг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

15.5. Мэдээллийн технологи, харилцаа холбоо, теле хяналтын чиглэлээр технологийн дэвшлийг цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх нэгдсэн бодлого боловсруулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үр дүнг үнэлж, дүгнэх, удирдлагад санал танилцуулах;

15.6. Мэдээллийн технологи, харилцаа холбоо, теле хяналтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтын бэлэн байдлыг хангуулах, засвар, үйлчилгээ үзүүлэх;

15.7. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бий болгох, түүний хэрэгжилтэд кибер аюулгүй байдлын дотоод аудит, эрсдэлийн үнэлгээг хийж хяналт тавих.

15.8. Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын шуурхай удирдлагын нэгж, бүрэлдэхүүнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

VI. Албаны нэгжүүдийн чиг үүрэг

16. Захиргааны удирдлагын хэлтсийн чиг үүрэг

16.1. Цагдаагийн байгууллагын зорилго, зорилт, хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн албаны ойрын болон хэтийн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

16.2. Албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сурган дадлагажуулах, мэргэшүүлэх, бие бялдрын бэлтгэл олгох ажил, арга хэмжээг зохион байгуулах;

16.3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, үйлчилгээний стандарт, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдүүлж хэвшүүлэх, алба хаагчдын ажлын үр дүн, мэргэшил, ур чадварын түвшин, сахилга, ёс зүйд тавигдах шаардлага, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

16.4.Алба хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх;

16.5.Удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үүрэг, ажлын чиглэлийн хэрэгжилтийг хангаж, биелэлт, үр дүнг тооцох, албаны эд хөрөнгө, зэвсэг, тусгай хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бэлэн байдлыг хариуцах;

17.Статистик мэдээллийн хэлтсийн чиг үүрэг

17.1.Цагдаагийн байгууллагад ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, сангийн бүрдүүлэлтэд хяналт тавих, статистикийн мэдээ, тайлан боловсруулах, хэрэглэгчдэд түгээх;

17.2.Эрх бүхий байгууллага, албан тушаалтныг гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн талаарх судалгаа, мэдээллээр хангах, лавлагаа олгох;

17.3.Гэмт хэрэг, зөрчлийн болон эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, лавлагаа олгох;

17.4.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын мэдээлэл, судалгааны ажил хариуцсан алба хаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг үнэлэх, дүгнэх;

18.Дүн шинжилгээ, судалгааны хэлтсийн чиг үүрэг:

18.1.Гэмт хэрэг, зөрчлийн статистик тоон мэдээнд дүн шинжилгээ хийх, удирдлагыг бодит мэдээ, мэдээллээр хангаж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах;

18.2.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан байгууллагуудтай хамтран тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, дүн шинжилгээ хийх, санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, цагдаагийн төв байгууллагын удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах;

18.3.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дүн шинжилгээ, судалгааны багийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж, үр дүнг тооцох;

18.4.Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээллийг тогтмол хугацаанд бэлтгэж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

18.5.Гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээлэл, нийгэм, эдийн засгийн суурь үзүүлэлт дээр динамик туршилт хийн, хэтийн төлөвийг тодорхойлох, дүн шинжилгээ, судалгаанд үндэслэн ажлын чиглэл, зөвлөмж боловсруулах, удирдлагыг бодлогын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;

18.6.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох, дүн шинжилгээ, судалгаа хийхэд цугларсан мэдээллээр сан бүрдүүлэх;

18.7.Ижил чиг үүрэгтэй бусад байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага судлах, орчин үеийн дэвшилтэт техник технологи, арга зүйг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

18.8.Удирдлагаас даалгасан цаг үеийн шинжтэй бусад судалгаа, дүн шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх.

19.Холбооны хэлтсийн чиг үүрэг:

19.1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд радио, телефон холбооны бодлогыг боловсруулах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

19.2.Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио, телефон холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, хэвийн ажиллагааг хангах;

19.3.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны радио холбоог шуурхай, тасралтгүй зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх;

19.4.Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийн байгууллагуудтай мэдээ, мэдээлэл солилцож, хамтран ажиллах;

19.5.Цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хооронд тусгай шуудан солилцох ажил, үйлчилгээг шуурхай зохион байгуулах,

19.6.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын мэдээлэл, холбооны технологийн ажил хариуцсан алба хаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг үнэлж, дүгнэх;

20.Мэдээллийн технологийн хэлтсийн чиг үүрэг:

20.1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх чиглэлээр нэгдсэн бодлого боловсруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

20.2.Мэдээллийн технологийн чиглэлээр судалгаа хийх, нэвтрүүлэх, ижил чиг үүргийн байгууллагуудтай харилцах;

20.3.Цагдаагийн байгууллагын хэмжээнд программ хангамж боловсруулах, мэдээллийн систем, өгөгдлийн сан бий болгох, мэдээллийн нэгдсэн сүлжээ, серверийн дэд бүтэц зохион байгуулах, шинэчлэх, сайжруулах ажлыг зохион байгуулах;

20.4.Цагдаагийн байгууллагын программ хангамж, гадаад дотоод нэгдсэн сүлжээний зохион байгуулалт, сервер, системийн дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах.

20.5.Төрийн болон төрийн бусад байгууллагуудтай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох дэд бүтэц үүсгэх, хэвийн ажиллагааг хангах.

20.6.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын мэдээлэл, холбоо технологийн ажил хариуцсан алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

21.Кибер аюулгүй байдлын хэлтсийн чиг үүрэг:

21.1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын кибер аюулгүй байдлын чиглэлээр баримтлах бодлогын баримт бичиг, дүрэм, журам, заавар боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж батлуулан, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

21.2.Кибер аюулгүй байдлын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

21.3.Кибер аюулгүй байдлыг хангах талаар шаардлагатай мэдээ, баримт бичгийг холбогдох байгууллагаас гаргуулж авах;

21.4.Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийж аюулгүй байдлыг сайжруулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

21.5.Мэдээллийн аюулгүй байдлын дотоод аудит, кибер аюулгүй байдлын эрсдийг бууруулах чиглэлээр хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг үнэлж, удирдлагад танилцуулах;

22. Шуурхай удирдлагын хэлтсийн чиг үүрэг:

22.1.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын хэлтэс, тасаг, жижүүрийн ажил хариуцсан алба хаагчдын үйл ажиллагаанд нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих, үр дүнг үнэлж, дүгнэх;

22.2.Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавих, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах хойшлуулшгүй ажиллагааг зохион байгуулах, хүч хэрэгслийн оновчтой хуваарилах, энэ чиглэлээр үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцож, шуурхай байдлыг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах;

22.3.Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын ажиллагаа хариуцсан нэгжийг хоногийн хугацаанд үйлдэгдсэн ноцтой гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллээр хангах;

22.4.Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн төрөл, үйлдэгдсэн цаг хугацаа, хор уршиг, бусад онцлог нөхцөл байдлыг үнэлж, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны удирдлагын шийдвэрээр хэргийн газрын үзлэгийг багийг томилон ажиллуулах;

22.5.Онцгой нөхцөл байдлын болон нөхцөл байдал хүндэрсэн үед удирдлагын шийдвэрээр нэгж, алба хаагчдын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах;

22.6.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Ноцтой гэмт хэргийг мэдээлэх (код 201) журам”-д заасан ноцтой гэмт хэрэг болон цаг үеийн шинжтэй, тодруулга мэдээллийг удирдлага, ЦЕГ-ын Шуурхай удирдлагын ажиллагаа хариуцсан нэгж (Шуурхай удирдлагын штаб)-д танилцуулж, өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх;

23.Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн чиг үүрэг:

23.1.Хүн, хуулийн этгээдээс тусгай дугаарын 101, 102, 103, 105 дугаарын утсаар ирүүлж буй гэмт хэрэг, зөрчил, гамшиг, осол, гал түймрийн болон эмнэлгийн яаралтай тусламжийн талаарх дуудлага, мэдээллийг шуурхай хүлээн авах, дамжуулах, зөвлөгөө өгөх, төрөл, мэргэжлийн албадын үйл ажиллагааг уялдуулан холбож, шуурхай удирдлагаар хангах;

23.2.Томоохон хэмжээний гамшиг, осол, гал түймэр, газар хөдлөлт, хүн, малын гоц халдварт өвчин, техникийн осол, объектын болон ойн түймэр, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед Улсын болон Нийслэлийн онцгой комиссыг шаардлагатай мэдээллээр хангах;

23.3. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хоногийн нөхцөл байдлын мэдээ, гамшиг, осол, гал түймрийн болон эмнэлгийн түргэн тусламжийн дуудлага, мэдээлэл, хамгаалах, аврах үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг нэгтгэн гаргаж, холбогдох албад, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд зохих журмын дагуу хүргүүлэх;

23.4. Цагдаагийн төв байгууллага, харьяа алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, Онцгой байдлын алба, Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх нэгжид улс, нийслэл хотын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гамшиг, осол, гал түймрийн аюулаас хамгаалах, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох, эмнэлгийн яаралтай тусламжийн дуудлагаар үйлчлэх үндсэн үйл ажиллагаанд холбоо, мэдээлэл, хяналт, шуурхай удирдлага, зохицуулалтын чиглэлээр дэмжлэг үзүүлэх;

23.5. Мэдээлэл, шуурхай удирдлагын үйл ажиллагаанд холбоо, мэдээлэл, теле хяналтын дэвшилтэт технологи, арга, аргачлал, туршлага, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг судлах, нэвтрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах, ашиглалтын бэлэн байдлыг хангах, түүний үр өгөөжтэй хэрэглээг нэмэгдүүлэх;

24. Цагдаагийн төв байгууллагын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын хэлтэс, тасгийн чиг үүрэг

24.1. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дамжуулах, хуваарилах, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах, хойшлуулшгүй ажиллагаа зохион байгуулах, хүч, хэрэгслийг оновчтой хуваарилах, энэ чиглэлээр үүрэг, чиглэл өгч, хяналт тавьж, үр дүнг тооцож, албаны шуурхай бэлэн байдлыг хангуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах;

24.2. Гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх, цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, судалгаа, танилцуулга бэлтгэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, дүн шинжилгээ, судалгаа хийж, дүгнэлт, санал боловсруулах,

24.3. Гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалалтад авах, сэжиглэгдсэн этгээдийг баривчлах зорилгоор тухайн нэгжийн хүч хэрэгслийг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж, үүрэг, чиглэл өгөх, үр дүнг тооцох;

24.4. Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг хянан харгалзах, хамгаалах, хуяглан хүргэх талаар тогтоосон журмыг мөрдүүлэх;

24.5. Албаны галт зэвсэг, сум, тусгай хэрэгсэл, бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтыг хариуцаж, байгууллагын аюулгүй байдлыг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, хяналт тавих;

24.6. Онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлд шилжүүлэх бэлтгэл хангах;

24.7. Олдож ирсэн гээгдэл баримт бичиг, эд зүйл, алдуул мал, амьтныг хүлээж авах, бүртгэх, зарлан мэдээлэх, хүлээлгэн өгөх;

24.8. Гэмт хэрэг, зөрчлийн болон эрүүгийн хэргийн шүүхээр

шийдвэрлэгдсэн иргэн, хуулийн этгээдийн талаарх лавлагааг зохих журмын дагуу олгох, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

24.9.Хоногийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, онцлох зарим үйл явдлын талаарх цаг үеийн мэдээллээр удирдлагыг шуурхай хангах, ноцтой гэмт хэргийн талаарх мэдээллийг авмагц Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх /код 201/ журам”-ын 201.2 дахь хэсэгт заасны дагуу ажиллах;

24.10.Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага үйлдэгдсэн, онц байдал зарласан, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гадаад орнуудын төрийн тэргүүн, дээд, өндөр хэмжээний зочид, төлөөлөгчдийн айлчлал, олон улсын дээд түвшний хурлын үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад нэгж, алба хаагчдыг холбох, харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах;

24.11.Гэмт хэрэг, зөрчил нь цаг үеийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй тохиолдолд хойшлуулшгүй арга хэмжээ хэрэгжүүлэх талаар нэгжийн удирдлагад санал танилцуулах;

24.12.Цагдаагийн байгууллагын радио холбоо, телефон, компьютер, теле хяналт, сүлжээний техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, ашиглалтын байдалд хяналт тавьж, албаны бэлэн байдлыг хангах;

24.13.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологийн ололт, арга, аргачлал нэвтрүүлэх чиглэлээр санал боловсруулах, танилцуулах;

24.14.Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах;

VII.Албаны даргын эрх хэмжээ

25.Албаны дарга дор дурдсан эрхийг хэрэгжүүлнэ.

25.1.Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, бусад хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

25.2.Албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлт, үр дүнг тооцох;

25.3.Харьяа төв, хэлтсийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцож, тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

25.4.Албаны үйл ажиллагааны явц, ажлын ачаалал, хэтийн төлөв байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, зохион байгуулалтын бүтэц, орон тооны асуудлаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

25.5.Хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд буюу Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гарах /код 136/ журам”-д заасны дагуу удирдлагын шийдвэр гаргах, алба хаагч, ажилтныг томилох, чөлөөлөх, шагнах, урамшуулах ба шагналд нэр дэвшүүлэх, алба хаагчдад сахилгын шийтгэл ногдуулах;

25.6.Нэгж, алба хаагчаас гаргасан санал, тус албаны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг хүлээн авч шийдвэрлэх, холбогдох дээд байгууллага, албан тушаалтанд уламжлах;

25.7.Албаны зохион байгуулалтын бүтцийн нэгж, алба хаагчийн үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх гомдлыг шийдвэрлэх, хууль бус, үндэслэлгүй шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох;

25.8.Албаны үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг тухай бүр цагдаагийн алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас гаргуулан авах, нууцад хамаарах аливаа мэдээлэлтэй танилцах;

25.9.Алба хаагчдыг гадаад, дотоодын сургалтад хамруулах, сургах, дадлагажуулах, шалган зааварчлах, сургалт, сурталчилгааны ажил, арга хэмжээг зохион байгуулах;

25.10.Цагдаагийн төв байгууллагын даргын эрх шилжүүлснээр гадаад, дотоодын ижил чиг үүргийн байгууллагад албыг төлөөлөх, хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, аливаа хэлбэрээр гэрээ, хэлцэл хийх;

25.11.Хууль тогтоомж, дүрэм, журмаар олгосон бусад эрх;

26.Албаны дарга дор дурдсан үүргийг хүлээнэ.

26.1.Албаны үйл ажиллагааны үр дүнг Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд даргын өмнө хариуцаж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилээр төлөвлөж, биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнах;

26.2.Албаны чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, судалгаа, төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлага, хяналтаар хангахад чиглэсэн харилцан уялдаа бүхий цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

26.3.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон хүлээлгэсэн үүргийг хэрэгжүүлэх;

26.4.Харьяа нэгжийн алба хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, тэднээс гаргасан бүтээлч санал, санаачлаг, орчин үеийн техник, технологийн шийдлийг дэмжих;

26.5.Харьяа нэгжүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, алба хаагчдын ажлыг үнэлж, дүгнэх, нууцыг хадгалах;

26.6.Албаны үйл ажиллагааны явц байдлыг улирал тутам, хүний нөөцийн болон бусад тулгамдсан асуудлыг тухай бүр ЦЕГ-ын удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэх.

26.7.Хууль тогтоомж, дүрэм, журмаар тогтоосон бусад үүрэг;

VIII.Албаны Дэд даргын эрх, үүрэг

27.Албаны Дэд бөгөөд Захиргааны удирдлагын хэлтсийн дарга дараах бүрэн эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

27.1.Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, бусад хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

27.2.Албаны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Монгол Улсын хууль тогтоомж, бусад эрх зүйн актын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөө,

дээд шатны байгууллага, албан тушаалтны тушаал, шийдвэр, үүрэг, албан даалгавар, ажлын чиглэлийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцож, танилцуулах;

27.3.Албаны үйл ажиллагааны чиглэлээр баримтлах бодлого, үндсэн чиглэл, ойрын болон хэтийн зорилт тодорхойлоход албаны даргад дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээллээр хангах;

27.4.Харьяа нэгж, алба хаагчаас гаргасан санал, албаны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг хүлээн авч албаны даргад танилцуулж, шийдвэр гаргуулах;

27.5.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагаа, бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

27.6.Алба хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах талаар бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлж, алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

27.7.Харьяа нэгжийн үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүйн байдалд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах;

27.8.Байгууллагын албан бичиг хэрэг, архивын ажлыг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулж, удирдлагын баримт бичиг зохион бүрдүүлэх үйл ажиллагааг удирдлагаар хангах;

27.9.Хууль тогтоомж, дүрэм, журмаар олгосон бусад эрх;

IX.Албаны харьяа нэгжийн дарга болон алба хаагчийн эрх, үүрэг

28.Албаны харьяа нэгжийн дарга дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

28.1.Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрхийг хэрэгжүүлэх;

28.2.Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг боловсруулах, батлуулах, биелэлтийг хангуулах;

28.3.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, явц байдлыг 7 хоног тутам албаны даргад танилцуулж, өгсөн үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэх;

28.4.Нэгж, алба хаагчдын аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хүний нөөцийн болон бусад тулгамдсан асуудлыг тухай бүр албаны даргад уламжлан шийдвэрлүүлэх;

28.5.Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга, ёс зүйн байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, ажлын төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүнг тогтоосон хугацаанд тооцож, үнэлж, дүгнэх;

29.Алба хаагч энэ дүрэмд заасан алба, харьяа нэгжийн чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

29.1.Алба хаагч эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас мэдээ, мэдээлэл гаргуулан авах, мэдээллийн санд байршсан мэдээлэлд нэвтрэх, ашиглах, дүн шинжилгээ хийх;

29.2.Статистик тоо баримт, судалгаа, дүн шинжилгээний явцад тогтоогдсон үр дүн, санал санаачилга, шинэ техник, технологи, арга, аргачлалыг цагдаагийн албаны үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр судалгаа, тооцоо санал гаргах, түүний сөрөг үр дагавар, эрсдэлийг тооцож хэрэгжилтийг нь хангах зөвлөмж, аргачлал боловсруулах;

29.3.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тохируулан практикт нэвтрүүлэх зорилгоор олон улсад нэвтэрсэн шинэ техник, технологи, тэргүүн туршлагыг судалж, энэ чиглэлээр дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

29.4.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын хэлтэс, тасаг, тэдгээрийн алба хаагчид (тасгийн дарга, жижүүрийн ахлах офицер, жижүүрийн офицер, мэдээлэл, судалгааны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, мэдээлэл, холбооны технологийн инженер, мэдээлэл хүлээн авагч)-д мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

29.5.Алба хаагч харилцан бие биенээ хүндэтгэх, туслах, хамтарч ажиллахаас гадна хөрвөх чадвартай байж, ээлжийн амралт эдлэх болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар эзгүй байгаа алба хаагчийн төлөвлөгөөт ажлыг тасалдуулахгүй явуулах;

29.6.Цагдаагийн байгууллагын мэдээллийн санг ашиглахдаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

29.7.Хууль тогтоомж, дүрэм, журмаар тогтоосон бусад эрх, үүргээр хангагдана.

Х.Хамтын ажиллагаа

30.Алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, албан тушаалтан албаны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргаж өгөх, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах үүрэгтэй.

XI.Хариуцлага:

31.Алба хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө болон албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтод заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

XII.Бусад зүйл:

32.Алба архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, стандартыг мөрдөж ажиллана.

33.Алба хаагч Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан баталгаагаар хангагдана.

34.Албаны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах ажлын байр, холбоо, техник хэрэгсэл, бичгийн хэрэгсэл, албаны автомашинаар хангагдана.

